



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

**Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан
шалгах комиссын бүрэлдэхүүн,
ажиллах дүрэм батлах тухай**

Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын архивын ажлын нийтлэг журмын 2 дугаар бүлгийн 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баримт нягтлан шалгах комисс (БНШК)-ын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Баримт нягтлан шалгах комиссын ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төвийн захирлын 2022 оны А/66 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

1813100027

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2024 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
4/13.... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Дэд захирал
Нарийн бичгийн дарга	Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан
Гишүүд	Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга
	Лавлагаа лабораторийн албаны дарга
	Ерөнхий нягтлан бодогч

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
013... дугаар тушаалын 2 дугаар хавсралт



БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Баримт нягтлан шалгах комисс (цаашид "БНШК" гэх) Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон бусад хууль, эрхзүйн баримт бичгүүдийг удирдлага болгон ажиллана.

Хоёр. Байгууллагын Баримт нягтлан шалгах комиссын зорилго

2.1. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан баримтыг архивт шижүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулах,

2.2. Байнгын хадгалалтад баримт сонгох болон төрийн архивт баримт шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах,

2.3. Устгах баримтын жагсаалтыг комиссын хурлаар хэлэлцэн баталж, зохих төрийн архиваас зөвшөөрөл авсны үндсэн дээр устгах ажлыг зохион байгуулах

Гурав. Байгууллагын Баримт нягтлан шалгах комиссын зохион байгуулалт

3.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн БНШК нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба комиссын бүрэлдэхүүнд Дэд захирал, Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан, Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга, Лавлагаа лабораторийн албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч байна.

3.2. БНШК нь Үндэсний төв архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссоос арга зүйн зөвлөгөө авч ажиллана.

3.3. БНШК нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хуралдан, хурлын шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлаар шийдвэрлэх асуудлыг комиссын Нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.4. Хурлыг тэмдэглэлийг комиссын Нарийн бичгийн дарга хөтлөн, комиссын Даргын гарын үсэг болон байгууллагын тэмдгээр баталгаажуулна.

3.5. Байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт, байнга, түр, 70 жил хадгалах баримтын бүртгэл, устгах хэргийн акт зэргийг хянан хэлэлцэх, уг баримт бичгүүдийг Үндэсний төв архиваар хянуулна.

3.6. Байнга хадгалах баримтуудыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйл заасан хугацаагаар байгууллагын архивт хадгалсны дараа холбогдох төрийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Баримт нягтлан шалгах комиссын үүрэг

4.1. Байгууллагын баримт хадгалах хугацааны жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, устгах хэргийн актыг хянан хэлэлцэх,

4.2. Байнга, түр хадгалах хэргүүд болон устгах хэргийг ялгах ажлыг жил бүр зохион байгуулах,

4.3. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.